

**ГХБХБГ-ЫН 9 ДҮГЭЭР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2018.09.06.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Энэ 7 хоногт байгууллагын цонх болон хаалганд дулаалга хийж, байгууллагын гадна талын орчин тойронд их цэвэрлэгээ хийлээ.</p> <p>ГХБХБГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Алтанцөгц, Баяннуур, Булган, Дэлүүн, Толбо, Ногооннуур сумдад газрын харилцааны хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шинжилгээ мониторингийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Гарсан алдаа дутагдлыг арилгах талаар тухай сум орон нутгийн удирдлагуудад зөвлөгөө өгч ажилласан болно.</p> <p>Эзэмшил газрын зориулалт өөрчлүүлэхийг хүссэн 1 иргэний хүсэлтийг Засаг даргын захирамжийн дагуу холбогдох өөрчлөлтийг газрын кадастрын мэдээллийн санд оруулж бүртгэв.</p> <p>Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хүссэн 2 иргэн, Эзэмшил газар нийтийн орон сууц барьж ашиглалтад оруулсан ба тухай эзэмшил газраа нийтийн эдэлбэрт шилжүүлэхийг хүссэн 1 иргэн, Газар эзэмшигч нь нас барьсан тул өв залгамжлалаар тухайн газрыг үргэлжлүүлэн эзэмшихийг хүссэн 1 иргэн, Засаг захиргааны хуваарилалтаар эзэмшил газрын багийн дугаар өөрчлөгдсөнийг зөвтгүүлж холбогдох өөрчлөлтийг улсын бүртгэлд оруулахыг хүссэн 1 Аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг аймгийн Засаг даргын захирамжийн дагуу ГКМС-нд оруулж эрхийн баталгаажуулалт хийсэн болно.</p> <p>Өлгий хотын төвд байгаа зарим орон сууцнуудын орчны газрыг тогтоох тухай аймгийн Засаг даргын захирамжийн дагуу мэдээллийн санд оруулан ажилласан болно.</p> <p>“Өлгийланд” ХХК-ны хийсэн 96 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын, “Эл эм ланд” ХХК-ны хийсэн 12 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нийт 108 иргэн аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрын газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч</p>	<p style="text-align: center;">Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

кадастрын мэдээллийн санд оруулсан болно.

Мөн сумдын даамлуудын үйлдэж өгсөн 78 газрын кадастрыг хянаж бүртгэлд оруулав.

Дэлүүн, Улаанхус сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар тендерээр шалгарсан “Инженер геодези” ХХК-тай тухайн сумдын төвд хот байгуулалтын суурь судалгаа авах, иргэдийн болон орон нутгийн удирдлагуудын санал авах, ерөнхий төлөвлөгөөний концепцыг боловсруулах ажлаар аймгийн ерөнхий архитектороос 2018 оны 08-р сарын 29-нээс 09-р сарын 01-ний хооронд хамтран ажиллав. Тухайн компанитай гэрээ байгуулагдаж, зургийн даалгавар боловсруулан батлуулах шатанд байна.

2018 оны 09-р сарын 05-ний өдөр аймгийн төв талбайд төрийн бүх байгууллагын "Хууль сурталчлах өдөрлөг"-ийн нэгдсэн арга хэмжээнд манай байгууллагын бүх албан хаагч идэвхтэй оролцож, салбарын хууль, тогтоомжийг иргэдэд нээлттэй сурталчлав.

Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. **Тухайлбал:**

Алтай сум: Энэ 7 хоногт шинээр газар эзэмшүүлэх 2 өргөдөл, газрын маргаантай 1 өргөдөл хүсэлтийг тус тус хүлээн авч бүртгэв.

Мөн бэлчээрийн газрын фото мониторингийн тайлан болон геодезийн цэг тэмдэгтийн тооллого явуулж мэдээ судалгааг ГХБХБГ-д хүргүүлэв.

Эд хөрөнгө, өмчлөх эрхийн гэрчилгээ авахыг хүссэн 1 хүний материалыг бүрдүүлж, кадастрын зураг хийж, аймгийн үл хөдлөх хөрөнгийн газарт хүргүүлсэн.

Бугат сум: 6 иргэний өргөдөл хүлээн авсан. Сумын төвийн 7 иргэний газрыг тодруулан тэмдэглүүлж өгөв. Мониторингийн тайланг хэвлэсэн байдлаар хүргэж өгөв.

1 иргэнд үл хөдлөх хөрөнгийн материал бүрдүүлж кадастрын зураг гаргаж өгөв. Газрын төлбөрт 5000 төгрөг тушаав.